

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын Ерөнхий боловсролын 5 дугаар сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн хураангуй аудитын тайлан

Аудитын код: ГСА-2026/044/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn
Говьсүмбэр аймаг
2026 он

Тэргүүлэх аудитор: Б.Сарантуяа
Утас: 70543179
Цахим хаяг: sarantuyab@audit.gov.mn
Аудитын менежер: Г.Наранбаяр
Цахим хаяг: paranbayarg@audit.gov.mn
Ингүүмэл жаргалант аудит ХХК
Захирал: Э.Батчимэг
Ахлах аудитор: Г.Энхтөр

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

42015 Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3 дугаар баг
Утас/Факс: 976-7054 3179
И-мэйл: goviumber@audit.gov.mn

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН СҮМБЭР
СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
5 ДУГААР СУРГУУЛИЙН ТӨСВИЙН
ШУУД ЗАХИРАГЧ О.ОДГЭРЭЛ ТАНАА

2026.02.25 № 45

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын ерөнхий боловсролын 5 дугаар сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай болон аудитын тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад тус байгууллага нь бүх үйл явцыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бусад асуудлын хэсэг

4226050204

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.САРАНТУЯА

Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын Ерөнхий боловсролын 5 дугаар сургуулийн 2025 оны
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

ХОЁР.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ :

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	810,707,575.31	606,533,374.25
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	461,820,489.99	183,673,411.41
31211	Төрийн сангийн харилцах	452,835,882.21	183,673,411.41
31218	Ахмадын сангийн харилцах	8,984,607.78	-
33	АВЛАГА	-	40,234,620.78
33510	Байгууллагаас авах авлага	-	40,000,000.00
33520	Хувь хүмүүсээс авах авлага	-	234,620.78
34	УРЬДЧИЛГАА	5,000,000.00	-
34600	Урьдчилж гарсан зардал	5,000,000.00	-
35	БАРАА МАТЕРИАЛ	343,887,085.32	382,625,342.06
351	Түүхий эд материал	61,393,809.41	71,218,955.01
35110	Тусгай зориулалттай материал	61,253,809.41	70,482,056.41
35130	Эм боох материал	140,000.00	736,898.60
354	Хангамжийн материал	282,493,275.91	311,406,387.05
35410	Бичиг хэргийн материал	2,846,050.00	3,918,550.00
35420	Аж ахуйн материал	165,132,960.86	197,231,740.86
35440	Түлш, шатах тослох материал	570,000.00	-
35460	Хүнсний материал	26,153,735.00	6,952,705.00
35470	Бусад хангамжийн материал	87,790,530.05	103,303,391.19
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,945,626,782.46	2,843,501,562.73
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,945,626,782.46	2,843,501,562.73
392	Биет хөрөнгө	2,627,362,782.42	2,525,187,562.65
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,563,526,072.63	2,563,310,072.63
39202	Хуримтлагдсан элэгдэл	(468,348,167.55)	(550,423,123.71)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	680,672,771.93	699,859,145.43
39206	Хуримтлагдсан элэгдэл	(219,145,004.43)	(242,259,666.95)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	170,758,891.68	159,530,856.78
39208	Хуримтлагдсан элэгдэл	(100,821,781.84)	(105,525,721.53)
39214	Бусад үндсэн хөрөнгө	1,200,000.00	1,416,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(480,000.00)	(720,000.00)
393	Биет бус хөрөнгө	318,264,000.04	318,314,000.08
39301	Програм хангамж	12,384,400.00	520,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(12,024,399.96)	(109,999.92)
39303	Бусад биет бус хөрөнгө	317,904,000.00	317,904,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	3,756,334,357.77	3,450,034,936.98
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	0.00	3,024,000.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0.00	3,024,000.00
41361	Байгууллагад төлөх өглөг	0.00	3,024,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	3,756,334,357.77	3,447,010,936.98
51	Засгийн газрын хувь оролцоо	3,756,334,357.77	3,447,010,936.98

Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын Ерөнхий боловсролын 5 дугаар сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,431,180,360.62	1,431,180,360.62
51101	Өмч: - төрийн	1,431,180,360.62	1,431,180,360.62
512	Хуримтлагдсан үр дүн	2,075,921,899.56	1,766,598,478.77
51210	Өмнөх үеийн үр дүн	1,636,570,727.72	2,075,921,899.56
51220	Тайлант үеийн үр дүн	439,351,171.84	(309,323,420.79)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	249,232,097.59	249,232,097.59
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	3,756,334,357.77	3,450,034,936.98

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/ Аудит хийсэн тайлан болон аудитын тайланд тусгагдсан тоон мэдээллийг дахин нягталж хянах, мэдээллийн үнэн зөвийг хариуцах

/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	4,168,527,316.18	4,213,666,418.77
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	122,230,616.18	135,258,718.77
120	Нийтлэг татварын бус орлого	122,230,616.18	135,258,718.77
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	12,574,700.00	15,210,200.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	7,096,200.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	12,574,700.00	8,114,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	99,725,554.38	37,976,168.63
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	9,930,361.80	82,072,350.14
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,046,296,700.00	4,078,407,700.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3,637,496,700.00	3,670,147,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,637,496,700.00	3,670,147,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	40,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	40,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	408,800,000.00	408,220,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	408,800,000.00	408,220,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,729,176,144.34	4,522,989,839.56
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,729,176,144.34	4,522,989,839.56
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,540,958,635.45	4,260,600,700.55
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,441,589,155.49	3,004,708,359.17
210101	Үндсэн цалин	1,622,289,294.49	1,919,965,720.17
210102	Нэмэгдэл	674,705,901.55	840,598,299.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	24,091,599.00	103,303,000.00
210104	Урамшуулал	120,502,360.45	140,841,340.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	299,021,157.27	363,575,100.03
210201	Тэтгэврийн даатгал	208,327,144.27	252,206,629.03
210202	Тэтгэмжийн даатгал	24,592,101.00	30,266,778.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	12,286,151.00	15,056,831.00
210204	Ажилгүйдлийн даатгал	10,763,152.00	13,208,972.00

Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын Ерөнхий боловсролын 5 дугаар сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

210205	Эрүүл мэндийн даатгал	43,052,609.00	52,835,890.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	375,798,153.36	380,577,215.99
210301	Гэрэл, цахилгаан	26,249,958.25	40,092,483.86
210302	Түлш, халаалт	284,402,697.03	283,255,912.13
210303	Цэвэр, бохир ус	65,145,498.08	57,228,820.00
2104	Хангамж, бараа материалын зардал	15,206,256.14	-
210408	Бараа материал акталсны зардал	15,206,256.14	-
2105	Нормативт зардал	60,564,016.00	82,026,889.20
210502	Хоол, хүнс	60,564,016.00	82,026,889.20
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	11,136,590.00	15,240,590.00
210604	Урсгал засвар	11,136,590.00	15,240,590.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	42,630,549.14	64,655,859.64
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,449,700.00	7,096,200.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	37,180,849.14	57,559,659.64
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	295,012,758.05	349,816,686.52
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	87,187,706.37	148,837,998.16
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	18,551,495.00	-
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	189,273,556.68	200,978,688.36
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	188,217,508.89	262,389,139.01
2132	Бусад урсгал шилжүүлэг	188,215,662.25	247,246,355.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	156,400,002.25	247,246,355.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	31,815,660.00	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,846.64	15,142,784.01
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,846.64	15,142,784.01
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	439,351,171.84	(309,323,420.79)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	439,351,171.84	(309,323,420.79)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	4,066,871,400.00	4,133,578,524.24
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	20,574,700.00	55,170,824.24
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	20,574,700.00	55,170,824.24
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	7,096,200.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	20,574,700.00	48,074,624.24
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,046,296,700.00	4,078,407,700.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3,637,496,700.00	3,670,147,700.00

Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын Ерөнхий боловсролын 5 дугаар сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,637,496,700.00	3,670,147,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	40,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	40,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	408,800,000.00	408,220,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	408,800,000.00	408,220,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	3,587,157,178.28	4,350,848,302.82
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,587,157,178.28	4,350,848,302.82
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,390,029,792.64	4,062,241,383.03
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,444,137,767.07	3,014,869,459.20
210101	Үндсэн цалин	1,510,148,198.52	1,758,760,175.98
210102	Нэмэгдэл	710,659,991.55	907,815,216.04
210103	Унаа хоолны хөнгөлөлт	23,685,949.00	102,726,936.00
210104	Урамшуулал	199,643,628.00	245,567,131.18
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	304,742,320.20	393,414,000.00
210201	Тэтгэврийн даатгал	206,048,511.71	267,522,000.00
210202	Тэтгэмжийн даатгал	25,307,670.30	31,473,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	12,568,414.59	15,736,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	12,163,504.62	15,736,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	48,654,218.98	62,946,100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	375,798,153.36	380,577,215.99
210301	Гэрэл, цахилгаан	26,249,958.25	40,092,483.86
210302	Түлш, халаалт	284,402,697.03	283,255,912.13
210303	Цэвэр, бохир ус	65,145,498.08	57,228,820.00
2105	Нормативт зардал	62,693,441.00	76,842,699.20
210502	Хоол, хүнс	62,693,441.00	76,842,699.20
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	33,000,000.00	12,500,000.00
210604	Урсгал засвар	33,000,000.00	12,500,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	48,790,849.14	68,263,859.64
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,489,700.00	7,096,200.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	43,301,149.14	61,167,659.64
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	120,867,261.87	115,774,149.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	91,748,462.87	95,249,249.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	29,118,799.00	20,524,900.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	197,127,385.64	288,606,919.79
2132	Бусад урсгал шилжүүлэг	197,125,539.00	233,229,515.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	165,309,879.00	233,229,515.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	31,815,660.00	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,846.64	55,377,404.79
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,846.64	55,377,404.79
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	479,714,221.72	(217,269,778.58)
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	114,757,350.00	60,877,300.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	114,757,350.00	60,877,300.00
2200	Дотоод эх үүсвэрээр	114,757,350.00	60,877,300.00

Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын Ерөнхий боловсролын 5 дугаар сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	114,757,350.00	60,877,300.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(114,757,350.00)	(60,877,300.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	364,956,871.72	(278,147,078.58)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	96,863,618.27	461,820,489.99
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	461,820,489.99	183,673,411.41

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,431,180,360.62	249,232,097.59	1,636,570,727.72	3,316,983,185.93
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,431,180,360.62	249,232,097.59	1,636,570,727.72	3,316,983,185.93
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	439,351,171.84	439,351,171.84
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,431,180,360.62	249,232,097.59	2,075,921,899.56	3,756,334,357.77
D01	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,431,180,360.62	249,232,097.59	2,075,921,899.56	3,756,334,357.77
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,431,180,360.62	249,232,097.59	2,075,921,899.56	3,756,334,357.77
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(309,323,420.79)	(309,323,420.79)
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,431,180,360.62	249,232,097.59	1,766,598,478.77	3,447,010,936.98

2.5.1 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан - Улсын төсөв

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Дүнгээр	%
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,152,747,200.00	4,347,598,211.03	(194,851,011.03)	104.69
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,152,747,200.00	4,347,598,211.03	(194,851,011.03)	104.69
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,906,041,800.00	4,114,368,696.03	(208,326,896.03)	105.33
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,196,928,300.00	3,014,869,459.20	182,058,840.80	94.31
210101	Үндсэн цалин	2,032,366,800.00	1,758,760,175.98	273,606,624.02	86.54
210102	Нэмэгдэл	1,048,713,700.00	907,815,216.04	140,898,483.96	86.56
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	102,726,936.00	(102,726,936.00)	-
210104	Урамшуулал	115,847,800.00	245,567,131.18	(129,719,331.18)	211.97
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	399,616,000.00	393,414,000.00	6,202,000.00	98.45
210201	Тэтгэврийн даатгал	271,738,900.00	267,522,000.00	4,216,900.00	98.45
210202	Тэтгэмжийн даатгал	31,969,300.00	31,473,100.00	496,200.00	98.45
210203	ҮОМШӨ-ний даатгал	15,984,600.00	15,736,400.00	248,200.00	98.45
210204	Ажилгүйдлийн даатгал	15,984,600.00	15,736,400.00	248,200.00	98.45
210205	Эрүүл мэндийн даатгал	63,938,600.00	62,946,100.00	992,500.00	98.45
2105	Нормативт зардал	84,740,800.00	76,842,699.20	7,898,100.80	90.68
210502	Хоол, хүнс	84,740,800.00	76,842,699.20	7,898,100.80	90.68

Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын Ерөнхий боловсролын 5 дугаар сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	67,406,700.00	69,462,259.64	(2,055,559.64)	103.05
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	7,096,200.00	(7,096,200.00)	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	67,406,700.00	62,366,059.64	5,040,640.36	92.52
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	157,350,000.00	166,703,062.00	(9,353,062.00)	105.94
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	136,045,200.00	145,398,262.00	(9,353,062.00)	106.87
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	21,304,800.00	21,304,800.00	-	100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	246,705,400.00	233,229,515.00	13,475,885.00	94.54
2132	Бусад урсгал шилжүүлэг	246,705,400.00	233,229,515.00	13,475,885.00	94.54
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	246,705,400.00	233,229,515.00	13,475,885.00	94.54
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	-	-	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	461,820,489.99		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	183,673,411.41		

2.5.2 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан – Орон нутгийн төсөв /төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Дүнгээр	%
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	408,220,000.00	393,077,215.99	15,142,784.01	96.29
21	УРСГАЛ ЗАРДАЛ	408,220,000.00	393,077,215.99	15,142,784.01	96.29
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	408,220,000.00	393,077,215.99	15,142,784.01	96.29
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	395,720,000.00	380,577,215.99	15,142,784.01	96.17
210301	Гэрэл, цахилгаан	35,000,000.00	40,092,483.86	(5,092,483.86)	114.55
210302	Түлш, халаалт	295,720,000.00	283,255,912.13	12,464,087.87	95.79
210303	Цэвэр, бохир ус	65,000,000.00	57,228,820.00	7,771,180.00	88.04
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	12,500,000.00	12,500,000.00	-	100
210604	Урсгал засвар	12,500,000.00	12,500,000.00	-	100

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ :

Аудитаар нийт **44.9** мянган төгрөгийн алдаа¹ илэрснийг аудитын явцад залруулсан байна.

Аудитаар нийт 7,124.5 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс, 3,176.3 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 4,498.2 мянган төгрөгийн 2 албан шаардлага, 450.0 мянган төгрөгийн 1 зөвлөмж өгсөн.

Аудитаар нийт 7,124.5 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс бага тул Өөрчлөлтгүй дүгнэлт өглөө.

Бусад хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой нийт 6 зөвлөмж өглөө.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын Ерөнхий боловсролын 5 дугаар сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
Ахмадын сангийн үлдэгдлийг илүү тайлагнасан.	1	44.9			1	44.9	1	44.9				
Дүн	1	44.9			1	44.9	1	44.9				

/Мянган төгрөгөөр/

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/Мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Төсвийн хөрөнгөөр торгуулийн мөнгө төлсөн.	1	100.0			1	100.0						
Анхан шатны баримтын бүрдэл дутуу баримтаар томлолтын зардал олгосон.	1	450.0					1	450.0				
Нэр бүхий 5 ажилтанд ээлжийн амралтын цалин дутуу тооцож олгосон байна.	1	3,398.2			1	3,398.2						
Нэр бүхий 7 ажилтантай хөдөлмөрийн харилцаа дуусгавар болгохтой холбоотойгоор ээлжийн амралтын цалин илүү тооцож олгосон байна.	1	3,176.3	1	3,176.3								
Дүн	4	7,124.5	1	3,176.3	2	3,498.2	1	450.0				

Үүнээс

Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын Ерөнхий боловсролын 5 дугаар сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил	/мянган төгрөгөөр/					
		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил							
Шилэн дансны цахим системд 641,019.8 мянган төгрөгийн дүн бүхий 58 мэдээллийг мэдээлээгүй.	1	641,019.8		1	641,019.8		
Дүн	1	641,019.8		1	641,019.8		
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил							
Ажилтны ажлын цаг ашиглалтын бүртгэлийг хөтөлж, архивлаагүй	1	-				1	-
Ээлжийн амралт олгох тухай мэдэгдлийг хөтлөөгүй	1	-				1	-
Ажилчдын цалингийн тооцооны хүснэгт, цалингийн картыг батлагдсан маягт зааврын дагуу хөтлөөгүй, ээлжийн амралтын цалингийн түүврийг архивлаагүй	1	-				1	-
Тооллогын үр дүн /илүүдэл, дутагдал/-г тооцож гаргасан баримт байхгүй, тооллогын комисс тооллогын тооцоо бодсон акт үйлдээгүй, эд хариуцагчаар баталгаажуулаагүй, тооллогын баримтыг нягтлан бодогчид хүлээлгэн өгөөгүй.	1	-				1	-
Боловсролын салбарт мөрдөж байгаа НБББББ-т заасан үндсэн хөрөнгийн элэгдэл тооцох хугацааг мөрдөөгүйгээс барилга байгууламжийн хуримтлагдсан элэгдлийг дутуу тооцсон	1	105,970.2				1	105,970.2
Гэрээний үр дүн, биелэлт, гүйцэтгэлийн хувийг тооцож ажиллаагүй	1	20,399.5				1	20,399.5
Дүн	6	126,369.7				6	126,369.7
Нийт дүн	7	767,389.5		1	641,019.8	6	126,369.7